

ЗАХИРГАА, ТӨЛӨВЛӨЛТ, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН
С.УЧРАЛЫН 2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Өмчийн тухай болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлэн, хэрэгжилтийг ханган ажиллах, боловсронгуй болгох”							
1.	Арга хэмжээ 1.1 Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд хамаарах бүх төрлийн баримт бичгийн (тушаал шийдвэр, албан бичиг, гэрээ, захирамжлалын баримт бичгийн төсөл гэх мэт) хууль эрх зүйн үндэслэлийг хянах, санал өгөх	Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь.	-	50%	Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд хамаарах бүх төрлийн баримт бичгийг өдөр тутам хянаж, хууль эрх зүйн үндэслэлийг зөв бичих, хууль тогтоомж, стандартыг хангуулахад анхаарч, санал өгч ажилласан.	01-06 сар	100%
2.	Арга хэмжээ 1.2. Албан хаагчдыг холбогдох хууль эрх зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах	Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь.	-	50%	Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотойгоор хууль эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл авахыг хүссэн албан хаагчдад тухай бүр зөвлөгөө, мэдээллээр хангаж ажилласан.	01-06 сар	100%
3.	Арга хэмжээ 1.3. Байгууллагын албан хаагчдын хэрэгцээ шаардлагад үндэслэн болон шинээр батлагдан гарсан хууль тогтоомж, дүрэм журмуудыг албан хаагчдад танилцуулах, шаардлагатай тохиолдолд сургалт хийх	Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь.	-	50%	Шинээр батлагдан гарсан хууль тогтоомж, дүрэм журмуудыг албан хаагчдад танилцуулах хуудсаар болон цахим системээр дамжуулан танилцуулж ажилласан.	01-06 сар	100%
4.	Арга хэмжээ 1.4. Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд дагаж мөрдөж байгаа тогтоол, дүрэм, журмуудад холбогдох	Үйл ажиллагааны	-	50%	Байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд дагаж мөрдөж байгаа тогтоол, дүрэм, журмуудад холбогдох нэмэлт,	01-06 сар	100%

	нэмэлт, өөрчлөлтийг оруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	гүйцэтгэлийн хувь.			өөрчлөлтийг оруулах шаардлага байгаа эсэхийг судлан ажиллаж байна.		
5.	Арга хэмжээ 1.5. Батлагдан гарсан хууль тогтоомжид нийцүүлэн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмуудыг шинэчлэн боловсруулж батлах, хэрэгжилтийг ханган ажиллах	Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь.	-	50%	Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмуудад хууль тогтоомжид нийцээгүй зохицуулалт байгаа эсэх, тэдгээрийг шинэчлэн боловсруулах шаардлага байгаа эсэхийг судалж, өдөр тутам хэрэгжилтийг ханган, албан хаагчдад зөвлөгөө, мэдээлэл, санал өгч ажилласан.	01-06 сар	100%
6.	Арга хэмжээ 1.6. Эрх бүхий байгууллагаас боловсруулан санал авахаар ирүүлсэн хууль тогтоомж, дүрэм, журмын төсөлд санал өгөх	Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь.	-	50%	-“Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”-ын төсөлд 2024.03.06-ны 1/412 дугаар албан бичгээр, -“Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн дүрэм”-ийн төсөлд 2024.03.07-ны 1/416 дугаар албан бичгээр, -“Тэтгэврийн нөөц санд хөрөнгө төвлөрүүлэх, бүртгэх, хуваарилах, байршуулах, мэдээлэх, хөрөнгө оруулах, өвлүүлэх, хяналт тавих” журамд 2024.04.18-ны 1/704 дугаар албан бичгээр, -“Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан 8 стандартын төсөлд санал авсан. -“Төрийн жинхэнэ албаны нөөц бүрдүүлэх, нөөцийн санг ашиглах журам”, -“Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх ёслолын журам”, -“Төрийн албаны тэргүүний ажилтан цол, тэмдгээр шагнах журам”, -“Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын төслүүдэд болон -Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хуулийн төсөлд тус тус санал өгсөн.	01-06 сар	100%

					-Мөн Багахангай, Багануур, Налайх дүүргийн үйлдвэрлэл, технологийн паркуудын дүрмийн төслийг хянаж, санал өгсөн.		
Зорилт 2. “Хэрэг, маргаан шийдвэрлэхэд оролцох”							
1.	Арга хэмжээ 2.1. Нийслэлийн өмчтэй холбоотой шүүхийн маргаанд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг даргаас олгосон итгэмжлэл болон байгууллагыг төлөөлж маргааныг шийдвэрлэхэд оролцох	Үйл ажиллагаа ны гүйцэтгэлийн хувь.	-	50%	Байгууллагыг төлөөлж оролцсон 3 маргаан шүүхээр шийдвэрлэгдсэн. Тухайлбал, 1.“Бигмайнд Бюлдинг” ХХК-ийн нэхэмжлэлтэй, “Солонго” орон сууцны хорооллын гаднах цэвэр усны шугам, бохир усны гол шугамын хамтран өмчлөгчөөр тогтоолгох тухай шаардлага бүхий нэхэмжлэлтэй хэргийн 2024.04.17-ны өдөр анхан шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. 2.Иргэн Г.Мөнхсайханы нэхэмжлэлтэй, Төрийн албанаас түр чөлөөлсөн тушаал гаргахгүй байгаа эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох, төрийн албанаас түр чөлөөлсөн тушаал гаргахыг даалгах шаардлага бүхий нэхэмжлэлтэй хэргийг 2024.05.27-ны өдөр анхан шатны шүүхээс нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, зарим хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. 3."Алаг даага" ХХК нарын 10 байгууллагын нэхэмжлэлтэй, НӨХГ-ын 1/1223 дугаар албан бичгээр өгсөн мэдэгдлийг хүчингүй болгуулах, НӨХГаас УБДС ТӨХК-д хүргүүлсэн 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 1422 дугаар, НӨХГ-ын 1/1348 дугаартай “Урт цагаан үйлчилгээний төвийн барилгын цахилгааныг хязгаарлах тухай” албан бичиг болон түүний дагуу цахилгаан хязгаарласан УБЦТС ТӨХК-ийн үйлдэл, УБДС-ийн улсын байцаагчийн албан шаардлагыг хууль бус болохыг тогтоож,	01-06 сар	100%

			цахилгаанаар хангахыг даалгах шаардлага бүхий хэргийн нэхэмжлэгч нар нэхэмжлэлээс татгалзсанаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсон. Нийслэлийн Өмчийн харилцааны газраас итгэмжлэлээр төлөөлж оролцож буй 7 хэргийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байгаагаас НЗД-ийг төлөөлж буй 2 хэрэг (“Алаг даага” ХХК-нарын /10 байгууллага/-ийн нэхэмжлэлтэй, НИТХ-ын 11/65 тогтоолын нэхэмжлэгч нарт холбогдох хэсгийг биелүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулж, хувьчлаагүй эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоолгох”, “НЗД-ын А/216 дугаар захирамжийг хууль бус байсан болохыг тогтоолгох”, “НИТХ-ын 129 дугаар тогтоолыг хууль бус байсан болохыг тогтоолгох, Эрчим хүчний барилга угсралтын трест ТӨХК-ийн нэхэмжлэлтэй, “Гэм хорын хохиролд 806,000,000 төгрөг гаргуулах тухай”), НИТХ-ийг төлөөлж оролцож буй 1 (Хар Чонот ХХК-ийн нэхэмжлэлтэй, нийслэлийн өмчийн урт цагаан үйлчилгээний төвийн 5-р корпус оруулсан хөрөнгө оруулалтын төлбөрийг гаргуулах тухай), байгууллагыг төлөөлж оролцож буй 4 хэрэг (НӨХГ-ын нэхэмжлэлтэй, иргэн Б.Ганцогтод холбогдох Нийслэлийн өмчийн байрыг албадан чөлөөлүүлэх, 49,370,400 төгрөгийг гаргуулах, Улаанбаатар радио ХХК-д холбогдох “Нийслэлийн өмчийн барилгаас албадан гаргуулах” шаардлага бүхий хэрэг, “Материал Импекс” ХК-ийн нэхэмжлэлтэй, 1.2013 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 2013/33 дугаар гэрээг хүчин төгөлдөр бус байх хэлцэлд тооцуулах, Хэлцлээр шилжүүлсэн Түвшин Өргөө	
--	--	--	---	--

					хотхон, 304-р байр, 2, 7, 12 тоот хаягт байрлах үл хөдлөх эд хөрөнгүүдийн үнийг төлүүлэх, Хэлцлээр шилжүүлсэн 108-р байрны 181 тоот, 113-р байрны 187 тоот хаягт байрлах үл хөдлөх эд хөрөнгүүдийг “Материал Импекс” ХК-ийн өмчлөлд буцаан шилжүүлэхийг даалгах, “Анома” ХХК-ийн нэхэмжлэлтэй, урт цагаан үйлчилгээний төвд оруулсан хөрөнгө оруулалтын төлбөр гаргуулах) байна.		
2.	Арга хэмжээ 2.2. Хууль хяналтын байгууллагад хэрэг, зөрчлийг шийдвэрлүүлэхэд оролцох, санал өгөх	Үйл ажиллагаа ны гүйцэтгэлийн хувь.	-	50%	“Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК-ийн хувьцаа эзэмшилтэй холбоотой асуудлаар Улсын бүртгэлийн ерөнхий газарт 2024.03.28-ны өдрийн 1/554 дугаар албан бичгээр гомдол гаргасан. Нийслэлийн өмч болох газрын балансад бүртгэлтэй 14 объекттой холбоотойгоор өмчлөл, эзэмшлийн асуудлыг шийдвэрлүүлж, хууль бус байж болзошгүй үйлдлийг шалгуулахаар Нийслэлийн Прокурорын газарт өргөдөл, гомдлыг гаргасан. Мөн нийслэлийн өмчтэй холбоотойгоор 3 асуудлыг Эрүүгийн хуульд заасан Авлигын эсрэг гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй байдлыг шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт өргөдөл гаргасан. Мөн бусад хэрэг, зөрчил маргаантай асуудлыг шийдвэрлүүлэхэд санал өгч ажилласан.	01-06 сар	100%
Зорилт 3. “Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх”							
1.	Арга хэмжээ 3.1.	Үйл ажиллагаа ны	-	50%	-Газрын даргын 2024.02.01-ний өдрийн “2023 оны нийслэлийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ, нийслэлийн өмчит хуулийн	01-06 сар	100%

	Бусад байгууллага болон байгууллагын ажлын хэсэгт орж ажиллах, удирдлагыг мэдээллээр хангах	гүйцэтгэлийн хувь.			этгээдийн ашиглалтгүй болон илүүдэлтэй ажлын байр, талбай, хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээг дүгнэх” ажлын удирдамжийн дагуу ажлын хэсэгт ажиллаж Баянгол дүүргийн 5, Баянзүрх дүүргийн 2 гэрээг дүгнэсэн. -АСГАТ/20240102001 кодтой Бэлтгэн нийлүүлэгч сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад хөндлөнгийн гишүүнээр, -БХОНӨААТҮГ/20240102029 кодтой СБД болон ЧД-ийн ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын байгууллагад нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалтад үнэлгээний хорооны гишүүнээр, -НЗДТГ/20240102006 кодтой Нийслэл, орон нутгийн өмчийн бүртгэл мэдээллийн цогц систем, программ хангамж тендер шалгаруулалтад үнэлгээний хорооны гишүүнээр, -НЗДТГ/20240101003 кодтой Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шатыг шинэчлэх тендер шалгаруулалтад хөндлөнгийн гишүүнээр тус тус ажилласан. -Газрын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн гишүүнээр ажиллаж, зөвлөлийн төлөвлөгөөнд тусгагдсан болон холбогдох бусад ажлуудыг гүйцэтгэж ажиллаж байна. -Мөн байгууллагын Ёс зүйн дэд хорооны гишүүнээр сонгогдож, хууль, журамд зааснаар чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаж байна.		
2.	Арга хэмжээ 3.2. Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн эрхэлсэн ажлын чиг үүрэгт хамаарах албан бичиг, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх	Албан бичиг, өргөдөл, гомдлын	-	50%	Тайлант хугацаанд иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн 6 хүсэлт, 2 гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэн хариу өгсөн.	01-06 сар	100%

		шийдвэрлэлтийн хувь			Нийт 70 албан бичгийг зөрчил гаргалгүй хугацаанд нь шийдвэрлэж, 77 албан бичгийг хууль зүйн үндэслэлтэйгээр боловсруулан бэлтгэж илгээсэн байна.		
3.	Арга хэмжээ 3.3. Үйл ажиллагааны явцад үүссэн хадгаламжийн нэгжүүдийг архивын ажилтанд хүлээлгэн өгөх	Үйл ажиллагааны гүйцэтгэлийн хувь.	-	100%	Үйл ажиллагааны явцад үүссэн хадгаламжийн нэгж болох 10 боть, хүний нөөцийн мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэх хугацаанд бий болсон 11 боть, эрх бүхий албан тушаалтны гүйцэтгэх чиг үүрэгтэй холбоотойгоор 2 боть баримтыг архивын ажилтанд хүлээлгэн өгсөн.	01-04 сар	100%
4.	Арга хэмжээ 3.4. 2024 оны "Тохижилт бүтээн байгуулалт"-ын жил төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний дагуу байгууллагын хэмжээнд арга хэмжээ шинээр санаачлан ажиллах	Төлөвлөгөөний хэрэгжилт	-	-	Тус арга хэмжээ нь 2024 оны хоёрдугаар хагас жилд хэрэгжих тул эхний хагас жилд тайлагнах боломжгүй.	-	-
5.	Арга хэмжээ 3.5. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарих	-Тарьсан модны тоо -Цэнэг усалгаа хийсэн байдал	2023 оны 05 дугаар сарын 12-ны өдөр, 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрүүдэд Налайх дүүргийн "Шинэ-Налайх" цэцэрлэгт	50%	2024.05.10-ны өдөр Налайх дүүргийн цэцэрлэгт хүрээлэнд 100 ширхэг хайлаас модыг тарьж, усалгаа, арчилгаа хийхэд оролцсон.	2024.05.01-2024.05.12	100%

			Хүрээл энд 5 шинэс модны суулгас ан				
6.	Арга хэмжээ 3.6. Байгууллага болон бусад газраас зохион байгуулсан олон нийтийн ажилд оролцох	Үйл ажиллагаа ны гүйцэтгэли йн хувь.	-	50%	-Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчидтай 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр хийсэн уулзалтад оролцсон. - Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/248 дугаар захирамжийн дагуу “Хаврын их цэвэрлэгээ” нэгдсэн арга хэмжээнд 2024.04.13-ны өдөр оролцсон. -Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд захирагчийн ажлын албаны дарга Ц.Төрхүүгийн “Бүх нийтийн их цэвэрлэгээ” арга хэмжээг зохион байгуулах ажлын удирдамжийн дагуу “Их наядын гүүрнээс баруун тийш голын урд хэсгээрээ Энхтайваны гүүр хүртэл голын эрэг дагуу” цэвэрлэгээг 2024.05.16-ны өдөр хийхэд оролцсон. -Нийслэлийн 385 жилийн ойн хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дунд зохион байгуулсан “UB QUIZ-385” асуулт хариултын тэмцээнд 2024.05.22-ны өдөр оролцсон.	01-06 сар	100%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7

1.	Арга хэмжээ 1. Байгууллага болон бусад газраас зохион байгуулсан сургалт, семинарт оролцох	Мэдлэг, чадвар дээшилсэн байдал	-	50%	-Нийслэлийн Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан “MS Excel /дунд шат, ахисан шат/” сургалтад 2024.02.07-ны өдөр, -“Цахим орчны боломжийг ашиглан ажлын бүтээмжээ нэмэгдүүлэх нь” сургалтад 2024.02.20-ны өдөр, -“Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого Алсын хараа 2050” сургалтад 2024.02.27-ны өдөр, -“Хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналт хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй” сургалтад 2024.03.12, 14-ний өдрүүдэд хамрагдаж ХБ67140324 дугаар гэрчилгээ авсан, -“Төрийн байгууллагад нийтлэг хөтлөгддөг баримт бичиг боловсруулах арга зүй” сургалтад 2024.04.09-ний өдөр тус тус хамрагдсан. -Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хууль, дагалдан гарсан хууль тогтоомж болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн ойлголт олгох сургалтад 2024.04.12-ны өдөр хамрагдсан. -БНХАУ-ын Шанхайн Удирдлагын Хүрээлэн ба Удирдлагын Академийн хамтын ажиллагааны хүрээнд Шанхайн Удирдлагын Хүрээлэнгийн профессор DONG Youhog 2024 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн “Мега хотын засаглалын шинэчлэл” сэдэвт цахим сургалтад хамрагдсан.	01-06 сар	100%
----	--	---------------------------------	---	-----	---	-----------	------

					-2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулагдсан Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Мьонхн хотын тойргийн даргын "Хот байгуулалт, төлөвлөлт, барилгын стандартын" талаарх лекцэд хамрагдсан. -Төрийн албаны зөвлөлөөс цахимаар зохион байгуулсан 7:4:10 сургалтуудад тус тус хамрагдсан. -Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зохион байгуулсан "Төрийн албан хаагчийн хөгжил, хамгаалал" хэлэлцүүлэгт 2024.05.30-ны өдөр оролцсон.		
2.	Арга хэмжээ 2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтанд хамрагдах, гэрчилгээ авах	Гэрчилгээ авсан байдал	-	100%	"Худалдан авах үйл ажиллагааны хөтөч" ТББ-аас зохион байгуулсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтанд 2024.01.17-2024.01.19-ний өдрүүдэд хамрагдаж 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 2024/0113 дугаар гэрчилгээг авсан.	2024.01.17-2024.01.23	100%
3.	Арга хэмжээ 3. Монгол улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрх зүйн магистрын хөтөлбөрт суралцаж 12 багц цагийн хичээл судалж, цуглуулах	12 багц цаг цуглуулсан байдал	-	50%	Монгол улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн эрх зүйн магистрын хөтөлбөрт суралцаж, 2023-2024 оны хаврын улиралд 3 багц цагийн 2 хичээлийг амжилттай судалж, нийт 6 багц цаг цуглуулсан.	03-05 сар	100%
4.	Арга хэмжээ 4. Хуульчийн мэргэжлийн шалгалтад орж хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх авах	Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх авсан байдал	-	-	Тус арга хэмжээ нь 2024 оны хоёрдугаар хагас жилд хэрэгжих тул эхний хагас жилд тайлагнах боломжгүй.	-	-

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

..... / С.УЧРАЛ/

2024.06.05